



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07/40

Булган

Г Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл Г  
сонгон шалгаруулах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.1.2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Санхүүгийн албаны дарга

ХЭАХН-ийн салбар зөвлөлийн гишүүн Б.Дэлгэрсайхан

Эмэгтэйчүүдийн зөвлөлийн төлөөлөл Т.Тунгалагтуяа

2. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болох жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, төслийг сонгон шалгаруулж, биелэлтийг 12 дугаар сард иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хэлэлцүүлэхийг хорооны дарга (Э.Амгаланбаяр)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ж.ДОЛООН-ОД



0721011

D:\Togtool\togtool 2022.docx